

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
2020-2024 ОНЫ “ШИНЭ ХӨГЖЛИЙН ЗАМ”  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.” гэсэн заалтыг үндэслэж, аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсрууллаа.

Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн ИТХ-ын 2020 оны сонгуульд оролцсон Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт тулгуурлан, улстөрийн нам, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд олон нийтийн саналд үндэслэн боловсруулж, 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөө тодорхойллоо.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, ногоон хөгжлийн бодлого, засаглалын бодлого гэсэн 4 бүлэг, ... тэргүүлэх зорилт, ... дэд зорилтоос бүрдэж байна.

## **1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

### **Өнөөгийн байдал. /Суурь түвшин/**

- 2016-2020 онд иргэдэд үзүүлж буй боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цэцэрлэг сургуулийн хүчинд чадлыг нэмэгдүүлэх сургалтын орчныг сайжруулах зорилго тавьж, улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс 20 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтээр цэцэрлэгийг 570 ороор, сургуулийг 1280 суудлаар нэмэгдүүлж, сургуулийн өмнөх боловсролын хүүхдийн тоо 0.1-0.3, ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн тоо 10-12.5 хувиар тогтмол өссөн.
- Суралцагчийг хөгжүүлэх, бие даан, бүтээлчээр суралцах арга зүйд сургах, зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдний хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш нараар хүний нөөцийг бүрдүүлэх зорилготой “Оюунлаг Булган”, “Амжилтын галт тэрэг” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, сургалтын үр дүнд сайжирч, сурагчдын ЭЕШ-д үзүүлж буй амжилт ахисан байна.
- Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж буй өвчнийг тогтоож, урьдчилан сэргийлэх, эмчилгээний чанар үр дүнг дээшлүүлэх, халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх, салбарын мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах, эмчилгээ, оношилгооны сүүлийн үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлж, техник хэрэгслээр хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
- Эрүүл мэндийн салбарт 10.0 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

- Иргэд биеийн тамираар хичээллэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах орчин нөхцөлийг сайжруулж, шинээр спортын 4 заал, 2 сургуульд биеийн тамирын талбай, хөл бөмбөгийн талбай байгуулсан.
- “Монгол нум сум” дэд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн, бүх сумдыг нум сум, хэрэглэл материалаар ханган, сургагч багш нарыг бэлдсэн.
- Өсвөрийн шигшээ багийг байгуулж, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулснаар Монголын хүүхдийн спортын 6-р их наадамд Булган аймгийн баг тэргүүн байр эзэлсэн ба насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үеийн улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг аймагтаа зохион байгуулж, тамирчдын амжилтыг ахиулсан.
- “Соёлын бодлого”, “Уртын дуу-Морин хуур” дэд хөтөлбөрийн хүрээнд уран нугаралт, амьд хөгжмийг сурталчлан хөгжүүлж, 4 сумын соёлын төв, аймгийн Музей, Хөгжимт жүжгийн театрын барилгад 718.0 сая төгрөгөөр их засвар хийж, 8 соёлын төв, аймгийн Музей, Хөгжимт жүжгийн театрыг нийт 80.0 сая төгрөгийн техник хэрэгслээр хангасан.
- Ардын урлагийн наадам, Хүүхдийн урлагийн наадмыг тус тус зохион байгуулж, шалгарсан 1000 гаруй уран бүтээлчид улсын уралдаан болон аймгийн 80 жилийн ойн баяр наадмын нээлтийн үйл ажиллагаанд оролцуулсан.
- Хөгжимт жүжгийн театрын 800 хүний суудалтай шинэ барилгын зураг төслийг 121.3 сая төгрөгөөр хийлгэсэн.
- Аймгийн хэмжээгээр нийт 19115 өрхийн 62214 хүн амтай болж, 2016 онтой харьцуулахад өрхийн тоо 1.7 хувь, хүн амын тоо 1.4 хувиар тус тус өсчээ. Харин аймгийн нийт хүн амын 60.3 хувийг хөдөлмөрийн насны хүн эзэлж байгаа бөгөөд 2016 онтой харьцуулахад 2.1 хувиар өсчээ. Нийт өрхийн 17.6 хувь нь аймгийн төвд, 30.2 хувь нь сумын төвд, 52.1 хувь нь хөдөөд амьдарч байна.
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ХЭДС-аас сүүлийн жилүүдэд 3.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж 6 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 5000 гаруй ажлын байрыг бий болгосон. Үүний үр дүнд хүн амын ажилгүйдлийн түвшин 2016 онд 8.2 хувьтай байсан бол 2020 оны эхний улирлын байдлаар 5.4 хувь болж 2.8 пунктээр буурсан байна.

Цаашид аймаг, орон нутгийн онцлог, хүн амын амьдралын хэв маяг, хэрэгцээ шаардлага, эрүүл мэнд, боловсролын түвшинд нийцсэн бодлого шийдвэрийг гарган хэрэгжүүлж, өрх, гэр бүлийн хөгжилд чиглэсэн хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай тулгарч байна.

### **1.1. Эрүүл мэнд**

“Эрүүл бие, саруул ухаан, сайхан сэтгэл” уриан дор аливаа төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.1.1. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлж, эмчилгээний

шинэ технологийг нэвтрүүлж, зарим төрлийн мэс заслыг шинээр хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- 1.1.2. Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхийг сайжруулж, техник тоног төрөөхөмж, автомашинаар үе шаттай хангана.
- 1.1.3. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэгт хамруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.1.4. Сувилахуйн тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт, шинэлэг аргуудыг нэвтрүүлнэ.
- 1.1.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтэний гадаад, дотоод сургалтад хамруулж, туршлага судлуулах, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулж, иргэд үйлчлүүлэгчид сэтгэл ханамжтай тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.6. "Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.7. Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтэй болгоно.

## **1.2. Биеийн тамир, спорт**

Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, амьдралын салшгүй хэсэг болгож, үндэсний болон өвөл, зуны спортуудыг дэмжиж, Булган аймгийн баг, тамирчдын улс, тив, дэлхий, түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

- 1.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог аймгийн хэмжээнд бүрдүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.
- 1.2.2. Үндэсний спорт болон уламжлалт тоглоом наадгай, олимпийн төрлийн спортуудыг бодлогоор дэмжиж, улс, олон улс, тив дэлхийн хэмжээний тэмцээн уралдаанд гаргах амжилтыг ахиулах, аймгийн өсвөрийн шигшээ багийг байгуулна.
- 1.2.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ.
- 1.2.4. Төрөлжсөн сургалттай "Спортын дунд сургууль"-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг шинээр баталж, хөгжлийн шинэ шатанд гарган, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.
- 1.2.5. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, гадаад харилцааг бэхжүүлнэ.

## **1.3 Соёл, урлаг**

Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, үндэсний өв уламжлалыг залгамжлан, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагыг хослуулан хөгжүүлнэ.

- 1.3.1. Анхдагч түмний бахархал, монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, орчин үеийн соёл, урлагийг түгээн дэлгэрүүлнэ.
- 1.3.2. Аймгийн Хөгжимт жүжгийн театрын болон Кино театрын барилгыг шинээр барьж, соёлын төвүүдийн барилгыг үе шаттай засварлаж, салбарын материаллаг баазыг сайжруулна.
- 1.3.3. Аймгийн соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон хөгжүүлж, урлаг, соёл, аялал жуулчлалын “Эвент” үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.3.4. Соёлын салбарын дэд хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж, соёл урлагийн тогтвортой хөгжлийн хангана.
- 1.3.5. Орон нутгийн соёлын байгууллагууд, иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилан соёлын өвийг хамгаалалтад авах, соёлын биет болон биет бус өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, цахим соёлын санг бүрдүүлнэ.
- 1.3.6. Соёл урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор бэлтгэн, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого баримтална.

#### **1.4 Боловсрол**

Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, төлөвшил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.

- 1.4.1. Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахуйд суралцах боломж олгох, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах бодлого баримтлан ажиллана.
- 1.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ангийн бүлгийн тоог нэмэгдүүлж, жирийн ангид шилжин суралцах чадварыг дээшлүүлэн, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.
- 1.4.3. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдийн "Насан туршийн боловсрол"-ыг дэмжих боломжийг бүрдүүлнэ.
- 1.4.4. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгох, тэдний нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарч ажиллана.
- 1.4.5. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, "Хүүхдэд ээлтэй" сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

## **1.5 Хөдөлмөр эрхлэлт**

Орон нутгийн бизнес эрхлэгчид, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинээр бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

- 1.5.1.Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
- 1.5.2.“Мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, суралцагсдын үйлдвэр дээрх дадлага хийх нөхцөлийг бүрдүүлж, МСҮТ-үүдийн сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 1.5.3.МСҮТ-үүдийн багш нарыг давтан сургах, мэргэшүүлэх, гадаад дотоодын сургуулиудтай хамтран ажиллах боломж нөхцөлийг бүрэлдүүлэх, богино хугацааны сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулна.
- 1.5.4.Өрхийн үйлдвэрлэл, жижиг худалдаа эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг худалдаалах төвийг сумдад байгуулж, борлуулалтаар дэмжинэ.
- 1.6.5.Өрхийн үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол, боломжтой иргэдийг дэмжиж зээлэнд хамруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байранд зуучлах замаар 5000-аас доошгүй ажлын байр бий болгоно.

## **1.6 Нийгмийн хамгаалал, халамж**

Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх халамж хамгааллын үйлчилгээг гэр бүлд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны болон хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, жендэрийн тэгш байдлыг нийгмийн бүх салбарт хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог дэмжсэн хөгжлийн төвүүдийг бий болгож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

- 1.6.1.Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны дүнд үндэслэн “Зорилтот өрхийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.6.2.Аймгийн хэмжээнд гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллана.
- 1.6.3.Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг ханган ажиллана.
- 1.6.4.Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж ажиллуулна.
- 1.6.5.Нийгмийн хамгааллын салбарын ажиллагсдын орон сууцны барилгыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулна.
- 1.6.6.“Ахмадын өргөө”, хүүхдийн “Жаргалант” зуслангийн барилгыг үргэлжлүүлэн барьж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.
- 1.6.7.“Цахим Монгол” арга хэмжээний хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.

## **2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

Аймгийн ДНБ 2019 онд 361.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 42.7 тэрбум төгрөгөөр, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5.9 сая төгрөгт хүрч, 2016 оноос 1.2 сая төгрөгөөр өссөн байна.

Салбараар нь авч үзвэл хөдөө, аж ахуйн салбарт ДНБ-ний 53.2 хувь буюу 192.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 36.6 тэрбум төгрөгөөр, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт 168.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь мөн оноос 43.7 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

“Шинэ хөдөө” төслийн хүрээнд 4 жилийн хугацаанд 4.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, үхэр, хонь, ямааны үүлдэр угсааг сайжруулах, тариаланчдыг дундын техник, тоног төхөөрөмжөөр хангах, “Чацаргана” төсөл хэрэгжүүлэх, сүү хадгалах хөргүүртэй чингэлэг, арьс шир боловсруулах тоног төхөөрөмж зэргийг нийлүүлээ.

Бэлчээрт инженерийн хийцтэй 118 худаг шинээр гаргаж, 160 гаруй мянган га бэлчээрийн талбайг усжуулж, 500.0 мянган толгой малыг усаар хангав.

Сум хөгжүүлэх сангаас 2017-2019 онд 632 төсөлд 3.9 тэрбум төгрөгийн зээл олгосноор 823 ажлын байр шинээр бий болж, 624 ажлын байр хадгалагдан үлдсэн байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас журмын дагуу 20 төслийг сонгон шалгаруулж, 1.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Ирэх жилүүдэд мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулан эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлж ажиллана.

### **2.1 Эдийн засгийн тогтвортой хөгжил.**

Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, иргэдийн амьжиргааны түвшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий тэргүүлэгч аймаг нэг болно.

2.1.1. Эдийн засгийн хөгжлийн 2021-2024 оны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 7.4 сая төгрөгт хүргэнэ.

2.1.2. Эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоод хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хөрөнгийг тогтвортой нэмэгдүүлж, бизнес эрхлэх орчныг бүрдүүлнэ.

2.1.3. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.

2.1.4. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.

2.1.5. Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай үр ашигтай болгож, төсвийн зардлын ил тод байдлыг хангана.

2.1.6. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлт, олон улсын стандарт нэвтрэлтийг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн

зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, удирдлагын бүх шатанд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.

## **2.2 Хөдөө аж ахуй**

Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

- 2.2.1. “Шинэ хөдөө-Булган” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх замаар гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангаж, газар тариалан, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг сайжруулна.
- 2.2.2. “Чинээлэг малчин” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, малын чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, дотоодод мал, махны худалдааг нэмэгдүүлэн, экспортод гаргаж, малчдын орлогыг өсгөнө.
- 2.2.3. Мал аж ахуй эрхлэлтийг дэмжих, өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээг 25 хувьд хүргэнэ.
- 2.2.4. Хадлан, бэлчээрийн талбайг зохистой ашиглах, нөхөн сэргээх, уст цэгийн хайгуул судалгаа хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.5. Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулна.
- 2.2.6. Хөдөө аж ахуйн салбарын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.
- 2.2.7. Атрын IV аяныг орон нутагт хэрэгжүүлж, хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлнэ.
- 2.2.8. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, аймгийн хүн амын хүнсний ногооны хэрэгцээг 50-аас доошгүй хувиар хангана.
- 2.2.9. Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг өмнөх оноос 2 дахин нэмэгдүүлж, хүнсний ногоо, нарийн ногооны нэр төрлийг олшруулж, сумдад өвлийн болон нарлаг хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлнэ.
- 2.2.10. Сум дундын 500-1000 тоннын багтаамжтай механикжсан зоорийг томоохон худалдааны төвийг түшиглэн барьж байгуулна.
- 2.2.11. Малын тэжээлийн ургамал тариалж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.12. Эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран үр үржүүлгийн аж ахуй нэгж байгуулж “Булган” сорт бий болгоно.

## **2.3 Үйлдвэрлэл, үйлчилгээ.**

Жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх таатай орчинг бүрдүүлж, инноваци, техник, технологийн нэвтрүүлэлтийг эрчимжүүлэх замаар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

- 2.3.1. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.
- 2.3.2. Орон нутгийн “Жижиг зээлийн сан”-г бий болгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 2.3.3. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, бусад уул уурхайн болон аж ахуйн томоохон байгууллагуудын захиалгат ажлыг орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлж, орлого нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.4. “Булган үйлдвэр технологийн төв”-ийг байгуулан, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, 1100 тонн ноос угаах хүчин чадалтай үйлдвэр барина.
- 2.3.5. Булган суманд мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр шинээр байгуулах төсөл санаачилж, хөрөнгө оруулалтыг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.3.6. Булган суманд бетон зуурмагийн үйлдвэр байгуулна.
- 2.3.7. Булган, Сайхан, Сэлэнгэ, Бугат, Орхон суманд шахмал түлшний үйлдвэр байгуулж, үйл ажиллагааг нь тогтворжуулна.
- 2.3.8. Хөвсгөл, Орхон аймгуудтай бизнес хамтын ажиллагааг өргөжүүлж, хөдөө аж ахуйн гаралтай хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бий болгоно.
- 2.3.9. Булган суманд стандарт шаардлагад нийцсэн өндөр зэрэглэлийн зочид буудал шинээр барьж ашиглалтад оруулна.
- 2.3.10. Сумын иргэдэд халуун ус, үсчин, гоо сайхан, хими цэвэрлэгээний үйлчилгээг тогтмол авах боломжийг нэмэгдүүлнэ.

### **3. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО.**

Аймгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд 2021-2024 онд 20 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, “Ногоон хөгжийн хэтийн зорилт”, “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгч, сүүлийн 4 жилд 1200 га талбайг ойжуулан, 96170 га талбайн ойн хортон шавжийг устгаж, Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Хутаг-Өндөр, Тэшиг, Баян-Агт сумын нийт 543186.53 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна.

Инженерийн хийцтэй 74 худаг гаргаж, 67 булаг шандын эхийг хашиж хамгаалснаар хүн ам, бэлчээрийн усан хангамж сайжирч, Баян-Агт, Булган, Сайхан, Рашаант, Дашинчилэн, Баяннуур сумын усан хангамж, ариутгах татуургын өргөтгөл шинэчлэлт хийжээ.

Аймгийн төвийн гэр хорооллын бүх айл өрхүүдэд хог хаягдлын ангилан ялгах савтай болгож, бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг тогтмолжуулж ажилласныг Хотуудын холбооноос үнэлж, Булган сумыг “Хамгийн цэвэрхэн хот”-оор 2 жил дараалан шалгаруулсан байна.

“Ус хангамж, ариутгах татуургыг хөгжүүлэх аймгийн бодлого, “Эрчим хүчний хэмнэлтийн бодлого” зэргийг боловсруулан хэрэгжүүлж, Булган сумыг дулаанаар бүрэн хангах 28 МВт-ын хүчин чадалтай дулааны станцыг ашиглалтад оруулж, Дэлхийн банкны 4,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар цахилгаан дамжуулах агаарын шугамыг СИП кабельд бүрэн шилжүүлсэн. Мөн Азийн хөгжлийн банкны 8.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр баригдаж байгаа төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөөд байна.

Авто замын салбарт улс,орон нутгийн төсвөөс сүүлийн 4 жилд нийт 45907.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто замын эхлэлийн 34.8 км, Булган сумын 4 дүгээр баг Зүүнтүрүүний 1.8 км, Нэгдсэн эмнэлгээс “НИК” ШТС хүртэлх 0,482 км, 3 дугаар багийн А-Б хэсгийн хооронд 0,55 км, Биеийн тамир, спортын газрын урд талаас нэгдсэн эмнэлгийн баруун хойд талын уулзвар хүртэлх 0,453 км хатуу хучилттай авто зам, замын байгууламж, Сэлэнгэ суманд 437.02 урт/метр төмөр-бетон гүүрний ажлыг дуусгаж, ашиглалтад оруулсан байна.

Ирэх дөрвөн жилд байгалийн өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан, нөхөн сэргээх замаар ашиглалтын нөөц бий болгох, аялал жуулчлалыг байгаль орчин, эдийн засгийн үр өгөөжтэй байдлаар бүсчилэн хөгжүүлж, хот төлөвлөлт, дэд бүтцийн салбарын хөгжлийг түргэсгэж, иргэдийн ая тухтай амьдрах орчин, нөхцлийг сайжруулна.

### **3.1. Байгаль орчин.**

Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлнэ.

3.1.1.Ундны усан хангамжийг бүрэн шийдвэрлэж, баталгаат ундны усаар хангагдсан аймаг болно.

3.1.2.Рашааны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, Булаг, шандын эхийг хашиж хамгаалан, хур бороо, цасны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж, Баяннуур сумын “Баян”, Могод сумын “Загаст”, Хишиг-Өндөр сумын “Хонхор” нуурыг сэргээнэ.

3.1.3.Аймгийн ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмшүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулна.

3.1.4.Гол мөрөн, нуур, цөөрмийг түшиглэсэн загас, шувуу, бусад төрлийн амьтдыг өсгөн үржүүлэх аж ахуй байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.1.5.Газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг судалгаанд үндэслэн зохион байгуулж, сүлжээг өргөтгөнө.

3.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

3.1.7.“Жорлонгоо өөрчилъе” аяныг жил бүр зохион байгуулж, гэр хорооллын айл өрхийг байгальд ээлтэй боловсон 00-той болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.1.8.Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон болон барилга, авто зам, дэд бүтэц, бүтээн байгуулалтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.

3.1.9.Хөрсний бохирдол, доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа хийж, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.10.Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.

### **3.2. Аялал жуулчлал.**

Байгаль, түүх, соёлын өвийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх

маркетингийн нэгдсэн бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно.

- 3.2.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 3.2.2. Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй технологи нэвтрүүлсэн ААНБ-ыг дэмжиж хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, татвар хураамжаас чөлөөлөх зэрэг цогц арга хэмжээ авч, "Ногоон гэрчилгээ" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Буриад өв соёл, урлаг, спортын "Их Алтаргана-2022" олон улсын их наадмыг зохион байгуулна.
- 3.2.4. "Шороон бумбагар", "Цогт хунтайжийн цагаан балгас", "Хар бухын балгас", "Шивээт улааны цогцолбор", "Бий булагийн балгас" зэрэг түүхийн дурсгалт газруудыг хамгаалж, түүх соёлын аялал жуулчлалын дэд бүтцээр холбох ажлыг зохион байгуулна.
- 3.2.5. "Диваажингийн сүм", "Цагаан суврага", "Бурхан багшийн энергийн цэцэрлэгт хүрээлэн", "Хатанбаатар С.Магсаржавын бунхантай цогцолбор", "Баруун замын байлдааны штаб музей", "Тамгын толгой", "4 аваргын хөшөө", "Анхдагч алтартнуудын хөшөө" зэрэг түүхэн дурсгалт газруудыг түшиглэн түүхэн аялал жуулчлалын маршрутаар дэд бүтцийг шийдвэрлэнэ.
- 3.2.6. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжин, хамтран ажиллана.
- 3.2.7. "Чингийн цагаан нуур"-ын орчимд "Ус, намгархаг газрын мэдээллийн төв" байгуулж, нүүдлийн шувуу, ховор ан амьтан ажиглах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг бий болгоно.
- 3.2.8. Улсын болон орон нутгийн авто зам дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулна.

### **3.3 Уул уурхай**

Уул урхайн салбарт экологийн болон нийгмийн хариуцлагын тогтолцоог бий болгон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байрыг нэмэгдүүлж, аймгийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.

- 3.3.1. Ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрлэлд хүний эрүүл мэнд, байгаль орчны сөрөг нөлөөлөл багатай дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, аюулгүй ажиллагааг хангасан ил тод, хариуцлагатай уул уурхайг бий болгоно.
- 3.3.2. Сайхан сумын Эрээний нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэн орон нутгийн хэрэглэгчдийг хангаж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.
- 3.3.3. Ус ашиглагч уул уурхайн аж ахуйн нэгжүүдийг бүрэн тоолууржуулж, гадаргын усны нөөцийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.3.4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг орон нутгийн аж ахуйн нэгжид давуу эрхээр олгож, барилгын материалын үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ.

- 3.3.5. Уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагын хүрээнд хийх хөрөнгө оруулалтыг аймаг, орон нутгийн бүтээн байгуулалт руу чиглүүлж, үр дүнг тооцно.
- 3.3.6. Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч, төсөл хэрэгжүүлэгчдийн нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, экологийн тэнцвэрт байдлыг хангана.

#### **3.4 Дэд бүтцийн төлөвлөлт, төв суурингийн хөгжил.**

Аймгийн дэд бүтцийн салбарын хөгжүүлж, иргэд ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.

- 3.4.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хөгжлийн хэтийн зорилт, хот төлөвлөлттэй уялдуулан иргэн, аж ахуйн нэгжүүдэд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг ил тод болгоно.
- 3.4.2. Аймгийн хэмжээнд инженерийн хийцтэй барилга байгууламжуудад үнэлгээ хийж, барилгын засвар, дулаалгын ажлын эрэмбийг тогтоож, хэрэгжүүлнэ.
- 3.4.3. Өрхийн орлогод нийцсэн, амины, түрээсийн гэх мэт инженерийн шийдэл бүхий орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, Булган суманд 150, сумдад нийт 200-аас доошгүй айлын орон сууц барина.
- 3.4.4. Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжийг судалж, хэрэгжүүлнэ.
- 3.4.5. "Сайн хашаа", "Гудамж" төслүүдийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ.
- 3.4.6. Булган сум, хөдөөгийн сумын төв суурин газруудын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 3.4.7. Аймгийн Хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу барьж дуусган, сум суурин газарт спортын болон хүүхдийн тоглоомын талбай бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, ногоон байгууламжийг 2 дахин нэмэгдүүлнэ.
- 3.4.8. Булган сумын "Сансар 1", "Сансар 2" саадыг усалгааны системтэй болгож, ногоон байгууламжийн тохижилтийг сайжруулахад анхаарч ажиллана.
- 3.4.9. Булган сумын гэр хорооллын гудамж талбайг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.
- 3.4.10. Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ашиглалтад оруулна.
- 3.4.11. Булган сумын Зүүнтүрүү багийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар төвлөрсөн дулаан хангамжтай болгоно.
- 3.4.12. Аймгийн төвийн хэрэглэгчдийг хэрэглээний халуун устай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 3.4.13. Сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамыг бетон тулгуур бүхий СИП кабелиар ээлж дараатайгаар сольж, хэрэглэгчдийг 2 тарифт тоолуурт шилжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 3.4.14. Тэшиг сум чиглэлд 35 кВ-ын ЦДАШ, 35/10 кВ-ийн дэд станцтай болгоно.
- 3.4.15. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

- 3.4.16.Авто зам, замын байгууламжийг өргөтгөж, Гурванбулаг-Хишиг-Өндөр-Орхон-Булган чиглэлийн 133.7 км, Орхон аймаг-Хялганат чиглэлийн 54 км авто замыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулна.
- 3.4.17.Булган суманд явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан зорчих хэсэг, дугуйн зам барих санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлнэ.
- 3.4.18.Булган суманд нийтийн тээврийн автобусны үйлчилгээг тогтмолжуулж, сурагчдын автобустай болгоно.
- 3.4.19.Ерөнхий зориулалтын бага оврын агаарын хөлгийн байнгын нислэг бий болгоно.
- 3.4.20.Багийн төвүүдийг үүрэн телефоны сүлжээнд хамруулж, нутаг дэвсгэрийн хэмжээгээр үүрэн холбоо, өндөр хурдны интернет ашилах нөхцөлийг бүрдүүлнэ.

#### **4. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

Булган аймгийн хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар 151 төрийн байгууллагад 3792 албан хаагч ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан "Булган аймгийн Төрийн албан хаагчдын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр /2019-2022/"-ийг батлуулан хэрэгжүүлж байгаа нь төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах улмаар нийгмийн баталгааг хангахад эерэг өөрчлөлтүүд гарч байна.

Мэргэшсэн тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх ажлын үндэс болсон төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэ шаардлага, ур чадварт нийцүүлэн боловсруулж, төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчийг шатлан дэвшүүлэх эрх зүйн орчныг аймгийн хэмжээнд бүрдүүлжээ.

Булган аймаг ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улс, АНУ зэрэг улс орнуудтай эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөө аж ахуй чиглэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.

“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, гэмт хэргийн гаралт буурч, илрүүлэлт 46.4 хувь болж, өмнөх оноос 25 хувиар өсчээ.

“Оюутан цэрэг” хөтөлбөрийг орон нутагт анх удаа амжилттай хэрэгжүүлсэн байна.

Онцгой байдлын газрын бэлэн байдлыг сайжруулах зорилгоор спорт, сургалтын төвийн барилгыг 120.0, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийг 28.0 сая төгрөгөөр барьж, нийт сумдыг 174.9 сая төгрөгийн багаж зэвсэглэмж, 6 сумыг бага оврын галын автомашинаар хангасан байна.

2020-2024 онд төрийн байгууллага, төрийн албаны хүний нөөцийн аудитыг тогтмол хийж, чадварлаг төрийн албыг бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, ажиллахын зэрэгцээ төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Уламжлалт харилцаатай болон шинээр харилцаа тогтоосон муж, хот, дүүрэгтэй хамтын ажиллагааг бодитой үр дүнд хүргэж, Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

#### **4.1 “Цахим Монгол” төрийн шуурхай үйлчилгээ**

Цахим хөгжлийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэнэ.

4.1.1. "Цахим Монгол" төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.

4.1.2. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

4.1.3. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана.

## **4.2 Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба-хүнд сурталгүй төрийн үйлчилгээ.**

Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.

4.2.1. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхардлыг арилгах ажлыг эхлүүлнэ.

4.2.2. Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эрх ашгийг дээдэлсэн зөв бодлогыг хэрэгжүүлнэ.

4.2.3. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.

4.2.4. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.

4.2.5. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг хэрэгжүүлнэ.

4.2.6. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, авилгаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж, төр иргэдийн энэ төрлийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.

4.2.7. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.

4.2.8. Аймгийн ЗДТГ-ын дэргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг шинээр байгуулна.

4.2.9. Аймаг, сумын ЗДТГ-ын албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэнэ.

4.2.10. Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлнэ.

4.2.11. Нийгэм, эдийн засгийн үр дүнтэй гадаад харилцааг хөгжүүлнэ.

## **4.3 Хууль, эрх зүй, батлан хамгаалах**

Иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангана.

4.3.1. Аймгийн төв болон сумдын төвийн камержуулалтын нэгдсэн системийг шинэчлэн засварлаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг авч, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.

- 4.3.2.Мансууруулах бодис хэрэглэгч, архинд донтогчдод эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.3.3.Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна.
- 4.3.4.Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.
- 4.3.5.Шүүхийн шинжилгээний албаны тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, нарийн мэргэжлийн хүний нөөцийг ажиллах нөхцөлөөр хангах, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулна.
- 4.3.6.Стандартын шаардлагад нийцсэн цагдан хорих, баривчлах байрыг шинээр барьж ашиглалтад оруулна.
- 4.3.7.Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.
- 4.3.8.Салбарын байгууллагуудын автомашин, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчилнэ.
- 4.3.9.Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох чадавхыг бэхжүүлж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ.
- 4.3.10.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдалыг хангах зорилгоор хил хамгаалах 0286-р ангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хилийн албанд сумдаас нийлүүлэх агтны тоог нэмэгдүүлнэ.
- 4.3.11.Орон нутгийн батлан хамгаалах ажиллагааг бэхжүүлж, зэвсэгт хүчний үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллана.
- 4.3.12.Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, цэргийн бэлтгэл үүрэгний сургалтын төв байгуулна.
- 4.3.13.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилэх, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах
- 4.3.14.“Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ”-г орон нутагт хэрэгжүүлж, аймагтаа үйл ажиллагаа явуулж буй МСҮТ-ийн суралцагчдыг “Оюутан-цэрэг” сургалтад хамруулна.
- 4.3.15.Зэвсэгт хүчний 234 ангийн бие бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангах талаар хамтран ажиллана.

----oooOOOooo---